



**“НЬЮ УЛААНБАТАР ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ” ХХК-ИЙН  
ХАНДИВЫН ХАЙРЦАГ БАЙРШУУЛАХ ЖУРАМ**

**DONATION BOX PLACEMENT PROCEDURE**

**B4/PT-TA -2022-02**

*Хэвлэлтийн дугаар 01*

**Төв аймаг  
2022 он**



## ЗОРЧИГЧ ТЕРМИНАЛЫН ГАЗРЫН ТҮРЭЭСИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ХЭЛТСИЙН “ХАНДИВЫН ХАЙРЦАГ БАЙРШУУЛАХ ЖУРАМ”

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК (цаашид “НУБИЭ” ХХК гэх) -ийн Зорчигч терминалын барилга дотор хандивын хайрцаг байршуулах үйл ажиллагаатай холбогдуулан “НУБИЭ” ХХК болон аж ахуйн нэгжтэй үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын (цаашид “Журам” гэх) зорилго оршино.
- 1.2 Хандивын хайрцаг гэдэг нь нийгмийн тодорхой зорилтот бүлэгт хүмүүнлэгийн зорилгоор дэмжлэг үзүүлэх сайн дурын үйл ажиллагаагаар нийтийн өгсөн мөнгөн хандив, тусламжийг хуримтуулах хайрцгийг хэлнэ.

### Хоёр. Ерөнхий зүйл

- 2.1 “НУБИЭ” ХХК нь аж ахуйн нэгжийн бичгээр ирүүлсэн хүсэлт болон Хандивын хайрцаг байршуулах журамд үндэслэн зөвшөөрөл олгоно.
- 2.2 “НУБИЭ” ХХК-аас Хандивын хайрцаг байршуулах зөвшөөрлийн дагуу жишиг хугацаа нь 3 (гурав) сар хүртэл хугацаатай байна.
- 2.3 “НУБИЭ” ХХК-аас олгосон дээрх зөвшөөрлийг зөвхөн зориулалтын дагуу ашиглана.

### Гурав. Зөвшөөрөл олгох, хугацаа сунгах, цуцлах

- 3.1 “НУБИЭ” ХХК нь хүсэлтэд зөвшөөрөл олгохдоо сайн дурын үйл ажиллагаа, нийгэмд оруулж буй хувь нэмрийг судалж үзээд хайрцаг байршуулах хүсэлтийг хүлээн авна.
- 3.2 Хүсэлт ирүүлэгч нь Монгол Улсын Засгийн Газартай хамтран ажилладаг төрийн болон төрийн бус байгууллага, Нэгдсэн Үндэсний Байгууллага түүний дэргэдэх Олон улсын хүмүүнлэгийн байгууллагатай хамтран ажилладаг байна.
- 3.3 “НУБИЭ” ХХК нь аж ахуйн нэгжид хандивын хайрцаг байршуулах зөвшөөрөл олгохдоо дараах баримт бичиг, нэмэлт мэдээллийг шаардаж болно. Үүнд:
  - Аж ахуйн нэгж, байгууллагын товч танилцуулга
  - Хандивын хайрцаг байршуулах зорилго, хугацаа
  - Аж ахуйн нэгжийн Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
  - Хамтран ажилладаг байгууллагуудын мэдээлэл болон түүнтэй холбоотой бусад баримт бичиг
  - Хандивын хайрцагны хэмжээ
  - Шаардлагатай бусад нэмэлт мэдээлэл
- 3.4 Хандивын хайрцгийг зөвхөн “НУБИЭ” ХХК-ийн заасан байршилд байршуулна.
- 3.5 “НУБИЭ” ХХК-ийн шаардлагад нийцсэн бусад аж ахуйн нэгжээс хандивын хайрцаг байршуулах хүсэлт ирээгүй тохиолдолд өмнөх зөвшөөрөл олгосон хандивын хайрцгийг үргэлжлүүлэн байршуулж болно.



## ЗОРЧИГЧ ТЕРМИНАЛЫН ГАЗРЫН ТҮРЭЭСИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ХЭЛТСИЙН “ХАНДИВЫН ХАЙРЦАГ БАЙРШУУЛАХ ЖУРАМ”

- 3.6 Хандивын хайрцагны хэмжээ нь өндөр 1400мм, өргөн 600мм, зузаан 300мм-аас ихгүй байна. Хандивын хайрцгийг бэлтгэхдээ дизайн, материалын талаар “НУБИЭ” ХХК-аас урьдчилан зөвшөөрөл авна.
- 3.7 “НУБИЭ” ХХК нь зөвшөөрөл олгогдсон аж ахуйн нэгжийг нисэх буудлын холбогдох дүрэм журмыг дагаж мөрдөөгүй тохиолдолд хандивын хайрцаг байршуулах үйл ажиллагааг шууд зогсоох, талбайгаас албадан гаргах зэрэг арга хэмжээ авах эрхтэй.
- 3.8 “НУБИЭ” ХХК нь нисэх буудлын аюулгүй байдал болон бусад шаардлагаар талбайг ашиглах шаардлагатай болсон тохиолдолд хандивын хайрцгийг нүүлгэхийг санал болгож болно. Дээрх тохиолдолд хандивыг хайрцгийг байршуулагч нь эсэргүүцэл үзүүлэхгүй.

### Дөрөв. Аж ахуйн нэгжийн эрх, үүрэг

- 4.1 Зөвшөөрөгдсөн талбайд хандивын хайрцаг байршуулахдаа шаардлагатай гэрэлтүүлэг, засал чимэглэл, нэмэлт тоног төхөөрөмж суурилуулах гэх мэт ажлыг гүйцэтгэх бол “НУБИЭ” ХХК-д урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авна.
- 4.2 Хандивын хайрцаг байршуулагч нь 4.1-т заасан нэмэлт засал чимэглэлийн ажил хийсэн тохиолдолд талбайг анхны байдалд нь эргүүлэн засварлаж оруулах үүрэгтэй ба түүнтэй холбогдон гарах зардлыг бүрэн хариуцна. Хэрвээ талбайг анхны байдалд оруулаагүй бол НУБИЭ ХХК талбайг засварлахад гарсан зардлыг хандивын хайрцаг байршуулсан аж ахуйн нэгжээс нэхэмжилнэ.
- 4.3 Зөвшөөрөгдсөнөөс бусад талбай руу хандивын хайрцгийг зөөвөрлөхийг хориглоно.
- 4.4 Хандивын хайрцаг байршуулах талбайд “НУБИЭ” ХХК-ийн зөвшөөрөлгүйгээр аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Мөн “НУБИЭ” ХХК-ийн хариуцсан барилга байгууламж, эд хөрөнгийг зөвшөөрөлгүйгээр хөдөлгөх, гэмтээхийг хориглоно.
- 4.5 Хандивын хайрцаг байршуулах үед техникийн болон хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллах бөгөөд зөрчсөнөөс болж бусдад хохирол учруулбал буруутай этгээд төлбөрийг барагдуулах үүрэгтэй.
- 4.6 Монгол Улсын Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуулийг удирдлага болгон Хандивын хайрцаг байршуулах хугацаанд болон дууссанаас хойш талууд үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг гуравдагч этгээдэд задруулахыг хориглоно.
- 4.7 “НУБИЭ” ХХК-аас олгосон зөвшөөрлийн хугацаа дуусмагц хандивын хайрцгийг зөөвөрлөж талбайг чөлөөлөх үүрэгтэй. Хандивын хайрцгийг зөөвөрлөх түүнтэй холбогдон гарах зардлыг “НУБИЭ” ХХК хариуцахгүй.



## ЗОРЧИГЧ ТЕРМИНАЛЫН ГАЗРЫН ТҮРЭЭСИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ХЭЛТСИЙН “ХАНДИВЫН ХАЙРЦАГ БАЙРШУУЛАХ ЖУРАМ”

---

### Тав. Хариуцлага

- 5.1 Журмыг зөрчсөн гэм буруутай аж ахуйн нэгж, байгууллага нь Монгол Улсын Иргэний хууль, Байгууллагын болон Хувь хүний нүүцэн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.
- 5.2 Журам, холбогдох хууль тогтоомж, дүрэм зөрчсөний улмаас бусдад учруулсан хохирлыг гэм буруутай этгээд бүрэн барагдуулна.
- 5.3 Хандивын хайрцагны бүрэн бүтэн, аюулгүй байдал, хуримтлагдсан хандивын мөнгөний хамгаалалт зэрэг үйл ажиллагааг хайрцаг байршуулж буй аж ахуйн нэгж, байгууллага бүрэн хариуцна.
- 5.4 Журмын 5.3-т заасан үйл ажиллагаанд “НУБИЭ” ХХК хариуцлага хүлээхгүй.



**ЗОРЧИГЧ ТЕРМИНАЛЫН ГАЗРЫН ТҮРЭЭСИЙН ҮЙЛЧИЛГЭЭ,  
ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ХЭЛТСИЙН “ХАНДИВЫН ХАЙРЦАГ  
БАЙРШУУЛАХ ЖУРАМ”**

Хавсралт 1

**Баталгааны хуудас**

Хандивын хайрцаг байршуулах журмыг уншиж танилцсан.

Журмыг хүлээн зөвшөөрсөн:

Байгууллагын нэр /...../

тэмдэг

Байгууллагыг төлөөлж:

Албан тушаал /...../

Овог нэр /...../

Гарын үсэг /...../

Тамга

Он .....Сар .....Өдөр .....

Хандивын хайрцаг байршуулах хугацаа

Эхлэх огноо : .....

Дуусах огноо: .....

Зөвшөөрсөн:

“Нью Улаанбаатар интернэйшнл эйрпорт” ХХК-ийн

Гарын үсэг

.....

.....

.....


.....



**ЗОРЧИГЧ ТЕРМИНАЛЫН ГАЗРЫН ТҮРЭЭСИЙН ҮЙЛЧИЛГЭЭ,  
ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ХЭЛТСИЙН “ХАНДИВЫН ХАЙРЦАГ  
БАЙРШУУЛАХ ЖУРАМ”**

Хавсралт 2

Хандивын хайрцгийг байршуулах байршил





**ЗОРЧИГЧ ТЕРМИНАЛЫН ГАЗРЫН ТҮРЭЭСИЙН ҮЙЛЧИЛГЭЭ,  
ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ХЭЛТСИЙН “ХАНДИВЫН ХАЙРЦАГ  
БАЙРШУУЛАХ ЖУРАМ”**

**Хавсралт 3**

НИСЭХ БУУДЛЫН ОЛОН НИЙТИЙН БОЛОН АЮУЛГҮЙН ХАМГААЛАЛТТАЙ БҮСЭД ХАНДИВЫН ХАЙРЦАГ БАЙРШУУЛАХ ЗОРИЛГООР ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, БАРАА МАТЕРИАЛ, НЭВТРҮҮЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН МАЯГТ

- Ерөнхий мэдээлэл:

Нэвтрэх байгууллагын нэр: .....		Албан тушаал: Нэр: Утасны дугаар:
Хугацаа:	Эхлэх огноо:	Хамгаалагдсан бүсэд хариуцах байнгын нэвтрэх үнэмлэхтэй ажилтан
	Дуусах огноо:	Байгууллага: Албан тушаал: Нэр: Гарын үсэг: Утасны дугаар:
Байршил: <input checked="" type="checkbox"/> Олон нийтийн бүс <input type="checkbox"/> Хилийн бүс /Нэвтрэх цэг: А23/		

- Бараа материалын мэдээлэл орох , гарах

№	Бараа материал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэмэлт мэдээлэл
1				
2				

- Хориглосон эд зүйл байгаа эсэх

№	Хориглосон эд зүйл	Эд зүйлийн нэршил	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Тайлбар /ашиглах зориулалт/
1	Шатамхай бодис				
2	Тэсэрч дэлбэрэх бодис				
3	Галт зэвсэг туслах хэрэгсэл				

Мэдээллийг АБХА-нд өгсөн.

Аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны газрын Аюулгүй байдлын үйл ажиллагааны төлөвлөлтийн мэргэжилтэн	Нэр	Гарын үсэг/ тэмдэг	Холбоо барих утас
	Д.Мөнхтөр		80050087 71287350 85050574



## ЗОРЧИГЧ ТЕРМИНАЛЫН ГАЗРЫН ТҮРЭЭСИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ХЭЛТСИЙН “ХАНДИВЫН ХАЙРЦАГ БАЙРШУУЛАХ ЖУРАМ”

Хавсралт 4

### Хандивын хайрцаг байршуулах үйл явц

